

2026.06.12 Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх, хүчингүй болгох тухай А/382

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авсан 4 иргэнд хавсралт ёсоор газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны А/315 дугаар захирамжийн хавсралтын 7 дугаар мөрийн Гомбосүрэн овогтой Базаррагчаад Эрдэнэ баг Чингэл 4-р гудамж 432 тоот 380 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны зориулалтаар, 2021 оны А/270 дугаар захирамжийн хавсралтын 15 дугаар мөрийн Одгэрэл овогтой Хишигбаатарт Эрдэнэ баг Сархиа 21-р гудамж 2101 тоот 809 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны зориулалтаар, 2022 оны А/217 дугаар захирамжийн хавсралтын 37 дугаар мөрийн Болдсайхан овогтой Үүрийнцолмонд Яргуйт баг Толгод 32-р гудамж 3247 тоот 767 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны зориулалтаар, 2020 оны А/110 дугаар захирамжийн хавсралтын 5 дугаар мөрийн Гансүх овогтой Урангоод Говил баг Арбулаг А-3-10-р гудамж 09 тоот 600 м.кв газрыг гэр бүлийн хэрэгцээний зуслангийн зориулалтаар” гэснийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлсэн иргэдийн хуучин гэрээ гэрчилгээг хураан авч хүчингүйд тооцон шинээр газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын даамал (Г.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.МӨНХБАЯР